



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/579

Улаанбаатар хот

Бакалаврын өдрийн хөтөлбөрт
2023-2024 оны хичээлийн жилийн хаврын улиралд
оюутан элсүүлэх журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Оюутан элсүүлэх журам” А/540 дүгээр тушаал, 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн “Босго оноо тогтоох тухай” А/97 дугаар тушаал, МУИС-ийн Дүрмийн 5.4.1, 5.4.8.9, дэх заалт, “МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны журам”-ын 4.2.2 дахь заалт, МУИС-ийн захиргааны зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэл, шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын их сургуулийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2023-2024 оны хичээлийн жилийн хаврын улиралд оюутан элсүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.


2. Тушаал гарсантай холбогдуулан элсэлтийн бодлого, журам сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Оюутны хөгжил эрхэлсэн захирал (Г.Галбаяр), Оюутны хөгжлийн бодлогын газрын дарга (В.Дашдаваа), Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын бодлогын газрын дарга, (С.Булгантамир), Цахим шилжилтийн бодлогын газрын дарга (А.Баатарбилэг) нарт үүрэг болгосугай.

3. Журмын дагуу элсэлтийн үйл ажиллагаа зохион байгуулахыг Оюутны хөгжил эрхэлсэн захирал (Г.Галбаяр), Сургалт эрхэлсэн захирал (Б.Батжаргал), Оюутны хөгжлийн бодлогын газрын дарга (В.Дашдаваа), Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын бодлогын газрын дарга, (С.Булгантамир), Цахим шилжилтийн бодлогын газрын дарга (А.Баатарбилэг), бүрэлдэхүүн болон салбар сургуулийн захирал (Д.Заяабаатар, Б.Амарсанаа, Н.Батнасан, С.Мөнхбат, О.Мөнхбат, М.Должин, Б.Ганбат, Ч.Сономдагва, Д.Алтанхуяг, Б.Баяржаргал, Ч.Удвалноров) нарт тус тус даалгасугай.

4. Элсэлтийн үйл ажиллагааны явц, үр дүн, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Оюутны хөгжил эрхэлсэн захирал (Г.Галбаяр), Сургалт эрхэлсэн захирал (Б.Батжаргал)-д үүрэг болгосугай.

5. Захирлын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/164 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын их сургуулийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2023-2024 оны намрын улиралд оюутан элсүүлэх журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ




Д.БАДАРЧ

1423094960

Захирлын 2023 оны 12 дугаар сарын 11-ны
өдрийн 1579 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ӨДРИЙН
ХӨТӨЛБӨРТ 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН
ХАВРЫН УЛИРАЛД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ



НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Монгол Улсын Их сургууль (цаашид МУИС гэнэ)-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2023-2024 оны хичээлийн жилийн хаврын улиралд оюутан элсүүлэхэд Монгол Улсын "Дээд боловсролын тухай хууль", Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 12 дугаар сарын 16-ны А/540 тоот тушаалаар баталсан "Оюутан элсүүлэх журам", Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн А/97 тоот "Босго оноо тогтоох тухай" тушаал, бусад холбогдох эрх зүйн акт болон энэхүү журам (цаашид журам гэнэ)-ыг баримтална.

1.2. МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг "бүртгүүлэгч", элсүүлэх оюутны тоог "хяналтын тоо", хяналтын тоонд багтан элсэх эрхээ баталгаажуулсан бүртгүүлэгчийг "элсэгч", элсэлтийн цахим бүртгэлийн системийг "элсэлтийн систем", элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг "элсэлтийн комисс" гэнэ.

1.3. МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт Улаанбаатар хот болон орон нутгаас элсүүлэх элсэгчийн хяналтын тоог Удирдах зөвлөл тогтооно. Намрын улирлын элсэлтээс үлдсэн хяналтын тоонд элсэлтийг зохион байгуулна.

1.4. Элсэлтийн журам, бүрэлдэхүүн сургуульд элсэх хөтөлбөр, элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЕШ)-ын оноо тооцох болон холбогдох бусад мэдээллийг <https://burtgel.num.edu.mn> элсэлтийн системд байршуулна.

1.5. МУИС-д гадаадын харьяат иргэнийг элсүүлэх асуудлыг "МУИС-д гадаадын иргэнийг суралцуулах журам"-аар зохицуулна.

ХОЁР. ЭЛСЭЛТИЙН КОМИСС

2.1 МУИС-ийн захирлын тушаалаар МУИС-ийн элсэлтийн комиссыг томилно. МУИС-ийн элсэлтийн комиссын дарга нь Оюутны хөгжил эрхэлсэн захирал, дэд дарга нь Сургалт эрхэлсэн захирал, нарийн бичгийн дарга нь Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын бодлогын газрын дарга, гишүүд нь Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн захирал, Эрдэм шинжилгээ эрхэлсэн захирал, бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирлууд, Оюутны хөгжлийн бодлогын газрын дарга, Цахим шилжилтийн бодлогын газрын дарга, Оюутны хөгжлийн төвийн эрхлэгч, Оюутны хөгжлийн бодлогын газрын элсэлт, шилжилт хариуцсан мэргэжилтнүүд байна. Ур чадварын шалгалтын комиссыг бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирлын тушаалаар томилно. Комисс нь ур чадварын шалгалтыг бүрэн хариуцаж зохион байгуулна.

2.2 Элсэлтийн комиссын дарга элсэлтийг зохион байгуулах ажлыг удирдлагаар хангаж ажиллах бөгөөд журмаар зохицуулаагүй асуудлыг бүрэлдэхүүн/салбар сургуулийн саналыг үндэслэн комиссын хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.

ГУРАВ. БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА

3.1 МУИС-д элсэхийг хүссэн иргэд энэхүү журамтай танилцаж, элсэлтийн системд бүртгүүлнэ.

3.2 Бүртгүүлэгч нь Боловсролын үнэлгээний төв (БҮТ)-өөс зохион байгуулдаг элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЕШ)-ын оноогоор жагсаж өрсөлдөнө.

3.3 Ур чадварын шалгалттай хөтөлбөрийг сонгосон бүртгүүлэгч ур чадварын шалгалт өгнө.

3.4 Бүртгүүлэгч нь МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль (ШУС), Бизнесийн сургууль (БС), Хууль зүйн сургууль (ХЗС), Улс төр, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль (УТОУХНУС), Мэдээллийн технологи, электроникийн сургууль (МТЭС), Инженер технологийн сургууль (ИТС), Завхан сургууль (ЗС), Ховд сургууль (ХС), Дорнод сургууль (ДС)-ийн хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрөөс сонгоно. Бүртгүүлэгч нь Элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн харьяалагдах хот, орон нутгаас үл хамааран бүрэлдэхүүн/салбар сургуулийн хөтөлбөрийн хяналтын тоонд жагсан өрсөлдөнө. Бүртгүүлэгч өөрийн хүсэлтээр хэдэн ч бүрэлдэхүүн сургууль/салбар сургуулийн хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрт бүртгүүлж болно.

3.5 Бүртгүүлэгч нь өөрийн хүсэлтээр хэдэн ч сургуулийн хэдэн ч хөтөлбөрт бүртгүүлж болно.

3.6 Бүртгүүлэгч нь Боловсролын үнэлгээний төв (БҮТ)-ийн хүчинтэй батламжтай, эсвэл 2023 онд ЭЕШ өгөхөөр БҮТ-д бүртгүүлсэн байна. Бүртгүүлэгч нь МУИС-ийн окутан бол бүртгүүлэх боломжгүй (Иргэнээр суралцаж байгаа суралцагчдад хамаарахгүй).

3.7 Гадаад оронд ерөнхий боловсрол эзэмшсэн Монгол улсын иргэн БШУЯ-ны сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ны А/347 тоот тушаалаар баталсан "Олон улсын шалгалтын үнэлгээг Монгол Улсын элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээтэй дүйцүүлэх журам"-ыг баримтална.

ДӨРӨВ. ЭЛСЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ

4.1 Орон даяар МУИС-д элсэхийг хүссэн иргэд, цахим хэлбэрээр <https://burtgel.num.edu.mn> системийн бакалаврын өдрийн элсэлт хэсэгт бүртгүүлнэ.

4.2 Бүртгэлийг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 09:00 цагт нээж, 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 12:00 цагт хаана.


4.3 Бүртгүүлэгч нь БҮТ-ийн системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан элсэлтийн системд нэвтэрнэ (Өмнө нь ЭЕШ өгсөн бол бүртгэл тус бүрээр хүсэлт гаргаж бүртгүүлнэ). Системд шаардлагатай мэдээллээ үнэн зөв оруулж баталгаажуулна.

4.4 Бүртгүүлэгч нь элсэлтийн системд оруулсан мэдээллийн үнэн зөв байдлыг өөрөө хариуцах ба алдаатай, буруу мэдээлэл оруулснаас үүсэх асуудлыг МУИС хариуцахгүй.

4.5 Элсэлтийн системд нэвтрэх эрхтэй болсны дараа элсэх хүсэлт гаргах бүрэлдэхүүн/салбар сургуулийн хөтөлбөр, хамтарсан хөтөлбөр (журмын хүснэгт 1-ээс үзнэ)-өөс сонгож, бүртгэлийн хураамжийг цахим хэлбэрээр төлж баталгаажуулна. (Төлбөр төлөх тухай дэлгэрэнгүй зөвлөмжийг элсэлтийн системээс үзнэ үү).

4.6 Бүртгэлийн хураамжийг нэг удаа төлж, хэдэн ч сургуулийн хэдэн ч хөтөлбөрт бүртгүүлэх боломжтой (Өмнө нь ЭЕШ өгсөн бол бүртгэл тус бүрээр хүсэлт гаргаж бүртгэлийн хураамж төлнө). Бүртгэлийн хураамжийг МУИС-ийн удирдах зөвлөлөөс баталсан "Үйлчилгээний бусад хураамжийн хэмжээ"-д заасны дагуу авна. Бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.

ТАВ. ЭЛСЭГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ



5.1 Бүртгүүлэгчийн ЭЕШ-ын дүн болон бусад мэдээллийг БҮТ-өөс элсэлтийн системд татан авч, холбогдох тооцооллыг хийж, онооны жагсаалтыг бүрэлдэхүүн/салбар сургуулийн хөтөлбөр, хамтарсан хөтөлбөр бүрээр гаргана.

5.2 Улаанбаатар хот дахь МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн хувьд "Суурь" болон "Дагалдах" шалгалтын оноо тус бүр 480, орон нутгийн салбар сургуулийн хувьд 410 онооноос багагүй байна. Суурь шалгалтад тооцуулсан хичээлийн оноог дагалдах шалгалтад давхар тооцохгүй.

5.3 Бүртгүүлэгчийн оноог дараах байдлаар тооцно. "Суурь" шалгалтад тооцохоор заасан хичээлээс хамгийн өндөр оноо авсан шалгалтын оноог 0.7, "Дагалдах" шалгалтад тооцохоор заасан хичээлээс хамгийн өндөр оноо авсан шалгалтын оноог 0.3-аар үржүүлж нэмсэн нийлбэрээр тооцоолсон оноог бодно. Улаанбаатар дахь бүрэлдэхүүн сургууль/салбар сургуулийн хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрийн тооцоолсон онооны босгыг журмын хүснэгт 1-д заасныг баримтална. Орон нутгийн салбар сургуулийн хувьд БШУЯ-аас баталсан их, дээд сургуульд элсэгчдийн хангасан байх босго онооноос багагүй байна.

5.4 Оноо тэнцсэн тохиолдолд ЭЕШ-ын гүйцэтгэлийн хувийг тооцон байр эзлүүлж, элсэх эрх олгох ба гүйцэтгэлийн хувь тэнцвэл боловсролын гэрчилгээний дундаж оноог харгалзана. ЭЕШ-ын гүйцэтгэлийн хувийг тооцохдоо энэ журмын 5.3-т заасан аргачлалын дагуу тооцно.

5.5 Ур чадварын шалгалт бүхий хөтөлбөрийн хувьд ур чадварын шалгалтыг тухайн бүрэлдэхүүн/салбар сургууль дээр зохион байгуулна. Элсэлтийн бүртгэл хааснаас 2 хоногийн дотор ур чадварын шалгалтыг зохион байгуулж, шалгалтын дүнг бүртгэлийн системд оруулна. Ур чадварын шалгалтыг 0-100 хүртэл оноогоор үнэлнэ. Тус оноог хэмжээст оноонд дараах байдлаар харгалзуулна.

	Шалгалтын оноо	Хэмжээст оноо
1	95-100	760-800
2	90-94	720-759
3	85-89	680-719
4	80-84	640-679
5	75-79	600-639
6	70-74	560-599
7	65-69	520-559
8	60-64	480-519
9	0-59	200-479

5.6 Ур чадварын шалгалтын хэмжээст оноог дагалдах шалгалтын оноогоор тооцно.

5.7 МУИС-ийн Байгаль эх лицей ахлах сургуулийн төгсөгчийг тухайн бүрэлдэхүүн/салбар сургуулийн суурь болон дагалдах шалгалтад тооцохоор заасан хичээлүүдээс ЭЕШ өгч, МУИС-ийн босго оноог хангасан бол ШУС, ИТС, МТЭС-ийн хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрт шууд элсүүлнэ. МУИС-ийн орон нутгийн лицей ахлах сургуулийн төгсөгчийг орон нутгийн салбар сургуулийн суурь болон дагалдах шалгалтад тооцохоор заасан хичээлүүдээс ЭЕШ өгч, БШУЯ-наас баталсан их, дээд сургуульд элсэгчдийн хангасан байх босго онооноос багагүй бол ДС, ЗС, ХС-ийн сонгосон хөтөлбөрт шууд элсүүлнэ.

5.8 “Байгаль эх лицей ахлах сургууль” гэсэн ангиллаар сонгон бүртгүүлж, энэ журмын 4.5-д заасан бүртгэлийн хураамж төлж, тухайн нөхцөл хангасныг гэрчлэх бичиг баримтын хуулбарыг, өргөдлийн хамт бүртгэлийн хугацаа хаахаас 3 хоногийн өмнө Оюутны хөгжлийн бодлогын газрын elselt@num.edu.mn цахим шуудан руу илгээж бүртгүүлнэ.

ЗУРГАА. ЭЛСЭХ ЭРХ ОЛГОХ

6.1. Орон даяар элсэх эрх олгох үйл ажиллагааг цахим хэлбэрээр <https://burtgel.num.edu.mn> системээр явуулна.

6.2. Бүртгүүлэгч хяналтын тоонд багтсан эсэхээ онооны жагсаалт гарсны дараа элсэлтийн системд нэвтэрч шалгана.

6.3. Лицей ахлах сургуулийг төгссөн бүртгүүлэгч нь заасан хугацаанд элсэн суралцах бүрэлдэхүүн/салбар сургуулийн ерөнхий суурь хичээлийн 1 багц цагийн төлбөрийг төлж элсэх эрхээ баталгаажуулна.

6.4. Элсэх эрх олгох үйл ажиллагааг 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 12:00 цагт эхлүүлж, 12 дугаар сарын 22-ны өдрийн 15:00 цагт дуусна.

6.5. Хэд хэдэн бүрэлдэхүүн/салбар сургуулийн хөтөлбөрийн хяналтын тоонд багтсан элсэгч нь зөвхөн нэг бүрэлдэхүүн/салбар сургуулийн нэг хөтөлбөр сонгоно. Сонгомгоц бусад бүрэлдэхүүн/салбар сургуулийн хяналтын тооны жагсаалтаас бүртгүүлэгчийн нэрийг хасаж, босго шугамыг нэгээр доошлуулна. Босго шугам доошилсны дүнд хяналтын тоонд багтсан дараагийн бүртгүүлэгчид элсэх эрх үүснэ.

6.6. Бүртгүүлэгч хяналтын тоонд багтаж элсэх эрхтэй болсноос хойш 4¹ /дөрвөн/ цагийн дотор элсэх эрхээ баталгаажуулна. Энэ хугацаанд баталгаажуулаагүй тохиолдолд МУИС-д элсэхээс татгалзсан гэж үзэж, жагсаалтад байгаа дараагийн бүртгүүлэгчдэд элсэх эрхийг шилжүүлнэ.

6.7. Хяналтын тоонд багтсан бүртгүүлэгч журмын 6.6-д заасан хугацаанд элсэлтийн системд нэвтэрч, элсэн суралцах бүрэлдэхүүн/салбар сургуулийн ерөнхий суурь хичээлийн 1 багц цагийн төлбөрийг төлж, элсэх эрхээ баталгаажуулна.


6.8. Элсэх эрхээ баталгаажуулсан төлбөрийг суралцагчийн сургалтын төлбөрт оруулан тооцно. Элсэх эрхээ цуцлах тохиолдолд төлбөрийг буцаан олгохгүй².

¹ Комиссын шийдвэрээр эрх баталгаажуулах хугацааг өөрчилж болно.

² Хуваарь буцааснаар дараагийн бүртгүүлэгч хуваарь авч чадахгүйд хүрч, эрх ашиг нь хөндөгддөг тул хариуцлагатай сонголт хийлгэх үүднээс урьдчилж төлүүлдэг.

ДОЛОО. ЭЛСЭГЧИЙГ БҮРТГЭХ

7.1. Элсэгч нь 2024 оны 01 дүгээр сарын 05-ны 15:00 цаг хүртэл <https://burtgel.num.edu.mn> системийн бакалаврын өдрийн элсэлт хэсэгт нэвтэрч маягт бөглөж, “МУИС-д суралцагч суралцуулах гэрээ”-г зөвшөөрсөн эсэхээ баталгаажуулж, цахим хэлбэрээр бүртгүүлж, оюутан болох хүсэлт илгээж, оюутны хувийн дугаар, нууц үг авна.



7.2. Энэ журмын 7.1-д заасан хугацаанд оюутан болж бүртгүүлээгүй тохилдолд МУИС-д элсэхээс татгалзсан гэж үзнэ.

НАЙМ. БУСАД

8.1. Бүртгэлийн хураамжийг илүү төлсөн, элсэх эрх баталгаажуулаагүй бүртгүүлэгчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн илүү төлсөн бүртгэлийн хураамж, баталгаажуулах төлбөрийг буцаан олгоно. Бүртгүүлэгч төлбөр буцаан авах хүсэлтээ 1 сарын дотор гаргана. Энэ хугацаанаас хойш төлбөр буцаах хүсэлт хүлээж авахгүй.

8.2 Бүртгүүлэгч нь энэхүү элсэлтийн журамтай биечлэн танилцсан байх үүрэгтэй.


8.3. Элсэлтийн үйл ажиллагаатай холбоотой гомдол маргааныг элсэлтийн комисс шийдвэрлэнэ.

8.4. МУИС-ийн 2023-2024 оны хичээлийн жилийн бакалаврын өдрийн хөтөлбөрийн элсэлтийг мэргэжлийн хөтөлбөрөөр авч байгаа нь БШУЯ-ны сайдын 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн “Босго оноо тогтоох тухай” А/97 тоот тушаалыг хэрэгжүүлж байгаа хэрэг бөгөөд энэ нь МУИС-д уламжлал болон тогтоод байгаа ливерал арт сургалтын үйл ажиллагаанд нөлөөлөхгүй болно.

БҮРЭЛДЭХҮҮН/САЛБАР СУРГУУЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЛБӨР,
ХАРГАЛЗАХ СУУРЬ БОЛОН ДАГАЛДАХ ШАЛГАЛТЫН ЖАГСААЛТ

№	СОНГОХ БОЛОМЖТОЙ БАКАЛАВРЫН ҮНДСЭН ХӨТӨЛБӨР /121 кредит цаг (ХЗС-ийн хувьд 151 кредит цаг)/	ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ		ТООЦООЛ- СОН ОНООНЫ БОСГО
		“СУУРЬ” шалгалт (70%)	“ДАГАЛДАХ” шалгалт (30%)	
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР				
1.	1. Аялал жуулчлал	· Математик · Монгол хэл	· Математик · Монгол хэл · Нийгэм судлал · Англи хэл	480
2.	2. Байгаль орчны зайнаас тандан судлал	· Математик · Физик	· Газарзүй · Нийгэм судлал	
3.	3. Биохими	· Биологи · Математик	· Хими · Англи хэл	
4.	4. Биотехнологи	· Биологи · Математик	· Биологи · Математик · Хими · Англи хэл	
5.	5. Биологи	· Биологи · Математик	· Биологи · Математик · Хими · Англи хэл	
6.	6. Математик	· Математик · Физик	· Математик · Физик · Нийгэм судлал · Англи хэл	
7.	7. Физик	· Математик · Физик	· Математик · Физик · Нийгэм судлал · Англи хэл	
8.	8. Физик электроник	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
9.	9. Хими	· Хими · Математик	· Хими · Биологи · Математик · Англи хэл	
10.	10. Газарзүй	· Газарзүй · Математик	· Газарзүй · Математик · Физик · Англи хэл	
11.	11. Геологи	· Математик · Физик	· Математик · Физик · Газарзүй · Англи хэл	
12.	12. Хот ба бүс нутгийн төлөвлөлт	· Математик · Физик	· Математик · Физик · Газарзүй · Англи хэл	
13.	13. Газар зохион байгуулалт	· Математик · Физик	· Газарзүй · Англи хэл	
14.	14. Геофизик	· Математик · Физик	· Газарзүй · Англи хэл	

15.	15. Биологийн нөөц судлал	· Биологи · Математик	· Хими · Нийгэм судлал	
16.	16. Экологи	· Биологи · Математик	· Хими · Нийгэм судлал	
17.	17. Хэрэглээний хими	· Хими · Математик	· Биологи · Англи хэл	
18.	18. Багш, математикийн боловсрол	· Математик	· Физик · Англи хэл	
19.	19. Багш, физикийн боловсрол	· Физик · Хими	· Математик · Физик · Хими · Англи хэл	
20.	20. Багш, химийн боловсрол	· Хими · Математик	· Хими · Биологи · Математик · Англи хэл	
21.	21. Багш, биологийн боловсрол	· Биологи · Математик	· Биологи · Математик · Хими · Англи хэл	
22.	22. Багш, газарзүйн боловсрол	· Газарзүй · Математик	· Газарзүй · Математик · Нийгэм судлал · Англи хэл	
23.	23. Ус судлал	· Математик · Физик	· Газарзүй · Нийгэм судлал	
24.	24. Цаг уур судлал	· Математик · Физик	· Газарзүй · Нийгэм судлал	
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР				
25.	1. Антропологи	· Түүх	· Нийгэм судлал · Англи хэл	480
26.	2. Археологи	· Түүх · Математик	· Нийгэм судлал · Монгол хэл	
27.	3. Хүн ам зүй	· Нийгэм судлал	· Түүх · Англи хэл	
28.	4. Нийгмийн ажил	· Нийгэм судлал · Англи хэл	· Нийгэм судлал · Монгол хэл · Англи хэл	
29.	5. Социологи	· Нийгэм судлал · Түүх	· Математик · Англи хэл	
30.	6. Сэтгүүл зүй	· Монгол хэл · Нийгэм судлал	· Түүх · Англи хэл	
31.	7. Сэтгэл судлал	· Нийгэм судлал · Математик	· Нийгэм судлал · Математик · Монгол хэл · Англи хэл	
32.	8. Эдийн засаг	· Математик	· Физик · Англи хэл	
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ САЛБАР				
33.	1. Гадаад хэлний орчуулга (Англи)	· Англи хэл · Нийгэм судлал	· Математик · Монгол хэл	480
34.	2. Гадаад хэлний орчуулга (Орос)	· Англи хэл · Нийгэм судлал	· Математик · Монгол хэл	
35.	3. Гадаад хэлний орчуулга (Солонгос)	· Англи хэл · Нийгэм судлал	· Математик · Монгол хэл	

36.	4. Гадаад хэлний орчуулга (Хятад)	· Англи хэл · Нийгэм судлал	· Математик · Монгол хэл		
37.	5. Гадаад хэлний орчуулга (Япон)	· Англи хэл · Нийгэм судлал	· Математик · Монгол хэл		
38.	6. Орон судлал (Америк)	· Англи хэл · Орос хэл	· Нийгэм судлал · Түүх		
39.	7. Орон судлал (Испани)	· Англи хэл · Орос хэл	· Нийгэм судлал · Түүх		
40.	8. Орон судлал (Итали)	· Англи хэл · Орос хэл	· Нийгэм судлал · Түүх		
41.	9. Орон судлал (Их британи)	· Англи хэл · Орос хэл	· Нийгэм судлал · Түүх		
42.	10. Орон судлал (Польш)	· Англи хэл · Орос хэл	· Нийгэм судлал · Түүх		
43.	11. Орон судлал (Солонгос)	· Англи хэл · Орос хэл	· Нийгэм судлал · Түүх		
44.	12. Орон судлал (Турк)	· Англи хэл · Орос хэл	· Нийгэм судлал · Түүх		
45.	13. Орон судлал (Франц)	· Англи хэл · Орос хэл	· Нийгэм судлал · Түүх		
46.	14. Орон судлал (Хятад)	· Англи хэл · Орос хэл	· Нийгэм судлал · Түүх		
47.	15. Орон судлал (Чех)	· Англи хэл · Орос хэл	· Нийгэм судлал · Түүх		
48.	16. Орон судлал (Япон)	· Англи хэл · Орос хэл	· Нийгэм судлал · Түүх		
49.	17. Утга зохиол судлал	· Монгол хэл	· Нийгэм судлал · Түүх		
50.	18. Урлаг судлал	· Монгол хэл	· Нийгэм судлал · Түүх		
51.	19. Хэл, уран зохиол (Монгол)	· Монгол хэл	· Нийгэм судлал · Түүх		
52.	20. Хэл шинжлэл (Монгол)	· Монгол хэл	· Нийгэм судлал · Түүх		
53.	21. Хэл шинжлэл (Хятад)	· Монгол хэл	· Нийгэм судлал · Түүх		
54.	22. Багш, гадаад хэлний боловсрол (Англи)	· Англи хэл · Орос хэл	· Монгол хэл · Нийгэм судлал		
55.	23. Багш, гадаад хэлний боловсрол (Орос)	· Англи хэл · Орос хэл	· Монгол хэл · Нийгэм судлал		
56.	24. Түүх	· Түүх · Математик	· Нийгэм судлал · Монгол хэл		
57.	25. Философи	· Нийгэм судлал · Математик	· Монгол хэл · Түүх		
58.	26. Шашин судлал	· Түүх · Нийгэм судлал	· Монгол хэл		
59.	27. Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол	· Монгол хэл	· Нийгэм судлал · Түүх		
60.	28. Багш, нийгмийн ухааны боловсрол (Түүх)	· Нийгэм судлал	· Монгол хэл · Түүх		
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ЭЛЕКТРОНИКИЙН СУРГУУЛЬ					
61.	1. Компьютерын ухаан	· Математик · Физик	· Математик · Физик · Англи хэл		600
62.	2. Мэдээллийн технологи	· Математик	· Математик		

		· <i>Физик</i>	· <i>Физик</i> · <i>Англи хэл</i>	
63.	3. Программ хангамж	· <i>Математик</i> · <i>Физик</i>	· <i>Математик</i> · <i>Физик</i> · <i>Англи хэл</i>	
64.	4. Мультимедиа технологи	· <i>Математик</i> · <i>Физик</i>	· <i>Англи хэл</i>	
65.	5. Мэдээллийн систем	· <i>Математик</i> · <i>Физик</i>	· <i>Англи хэл</i>	
66.	6. Статистик	· <i>Математик</i> · <i>Физик</i>	· <i>Математик</i> · <i>Физик</i> · <i>Нийгэм судлал</i> · <i>Англи хэл</i>	550
67.	7. Хэрэглээний математик	· <i>Математик</i> · <i>Физик</i>	· <i>Нийгэм судлал</i> · <i>Англи хэл</i>	
68.	8. Электроникийн инженерчлэл	· <i>Математик</i> · <i>Физик</i>	· <i>Математик</i> · <i>Физик</i> · <i>Англи хэл</i>	500
69.	9. Компьютерын сүлжээ	· <i>Математик</i> · <i>Физик</i>	· <i>Нийгэм судлал</i> · <i>Англи хэл</i>	
70.	10. Холбооны технологи	· <i>Математик</i>	· <i>Физик</i> · <i>Англи хэл</i>	
ИНЖЕНЕР ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ				
71.	11. Цөмийн инженерчлэл	· <i>Математик</i>	· <i>Физик</i> · <i>Англи хэл</i>	
72.	12. Сэргээгдэх эрчим хүч	· <i>Математик</i> · <i>Физик</i>	· <i>Математик</i> · <i>Физик</i> · <i>Англи хэл</i>	
73.	13. Био-инженерчлэл	· <i>Математик</i> · <i>Физик</i>	· <i>Математик</i> · <i>Физик</i> · <i>Хими</i> · <i>Англи хэл</i>	
74.	14. Материал судлал, инженерчлэл	· <i>Математик</i> · <i>Физик</i>	· <i>Математик</i> · <i>Физик</i> · <i>Хими</i> · <i>Англи хэл</i>	
75.	15. Нано шинжлэх ухаан, инженерчлэл	· <i>Математик</i> · <i>Хими</i>	· <i>Математик</i> · <i>Физик</i> · <i>Хими</i> · <i>Англи хэл</i>	480
76.	16. Химийн инженерчлэл	· <i>Математик</i> · <i>Хими</i>	· <i>Математик</i> · <i>Физик</i> · <i>Хими</i> · <i>Англи хэл</i>	
77.	17. Хүрээлэн буй орчны инженерчлэл	· <i>Математик</i> · <i>Хими</i>	· <i>Математик</i> · <i>Физик</i> · <i>Хими</i> · <i>Англи хэл</i>	
78.	18. Химийн боловсруулалтын технологи	· <i>Математик</i> · <i>Хими</i>	· <i>Физик</i> · <i>Англи хэл</i>	
79.	19. Хүрээлэн буй орчин судлал	· <i>Хими</i> · <i>Математик</i>	· <i>Биологи</i> · <i>Нийгэм судлал</i>	
80.	20. Ойн аж ахуй	· <i>Газарзүй</i> · <i>Математик</i>	· <i>Газарзүй</i> · <i>Математик</i> · <i>Биологи</i> · <i>Нийгэм судлал</i>	

БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ/ ХУДАЛДАА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН СУРГУУЛЬ				
81.	1. Нягтлан бодох бүртгэл	· Математик	· Англи хэл · Нийгэм судлал	600
82.	2. Санхүү	· Математик	· Англи хэл · Нийгэм судлал	
83.	3. Банк	· Математик	· Англи хэл	520
84.	4. Даатгал	· Математик	· Англи хэл	
85.	5. Маркетинг	· Математик	· Англи хэл	
86.	6. Менежмент	· Математик	· Англи хэл	
87.	7. Худалдаа	· Математик	· Англи хэл	
88.	8. Зочлох үйлчилгээ	· Нийгэм судлал	· Монгол хэл · Түүх	
ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ				
89.	1. Эрх зүй	· Нийгэм судлал	· Математик	600
УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ				
90.	1. Олон улсын харилцаа	· Англи хэл · Орос хэл	· Нийгэм судлал · Түүх	600
91.	2. Нийтийн удирдлага	· Нийгэм судлал	· Англи хэл	
92.	3. Улс төр судлал	· Нийгэм судлал	· Монгол хэл · Түүх	480
ЗАВХАН АЙМАГ ДАХЬ САЛБАР СУРГУУЛЬ				
93.	1. Нягтлан бодох бүртгэл	· Математик	· Англи хэл · Нийгэм судлал	410
94.	2. Санхүү	· Математик	· Англи хэл · Нийгэм судлал	
95.	3. Банк	· Математик	· Англи хэл	
96.	4. Маркетинг	· Математик	· Англи хэл	
97.	5. Менежмент	· Математик	· Англи хэл	
ДОРНОД АЙМАГ ДАХЬ САЛБАР СУРГУУЛЬ				
98.	1. Гадаад хэлний орчуулга (Хятад)	· Англи хэл · Нийгэм судлал	· Математик · Монгол хэл	410
99.	2. Түүх	· Түүх · Математик	· Нийгэм судлал · Монгол хэл	
100.	3. Нягтлан бодох бүртгэл	· Математик	· Англи хэл · Нийгэм судлал	
101.	4. Бизнесийн удирдлага	· Математик	· Англи хэл	
102.	5. Газрын тосны инженерчлэл	· Математик · Физик	· Математик · Физик · Газарзүй · Англи хэл	
103.	6. Нийгмийн ажил	· Нийгэм судлал · Англи хэл	· Нийгэм судлал · Монгол хэл · Англи хэл	
104.	7. Аялал жуулчлал	· Математик · Монгол хэл	· Математик · Монгол хэл · Нийгэм судлал · Англи хэл	
105.	8. Сэтгэл судлал	· Нийгэм судлал · Математик	· Нийгэм судлал · Математик · Монгол хэл · Англи хэл	
106.	9. Мэдээллийн технологи	· Математик · Физик	· Математик · Физик · Нийгэм судлал · Англи хэл	

107.	10. Багш, дизайн технологийн боловсрол	· Монгол хэл · Нийгэм судлал	· Ур чадвар		
108.	11. Багш, дизайн зураг зүйн боловсрол	· Монгол хэл · Нийгэм судлал	· Ур чадвар		
109.	12. Багш, дүрслэх урлагийн боловсрол	· Монгол хэл · Нийгэм судлал	· Ур чадвар		
110.	13. Багш, биеийн тамирын боловсрол	· Монгол хэл · Нийгэм судлал	· Ур чадвар		
111.	14. Багш, сургуулийн өмнөх боловсрол	· Монгол хэл · Нийгэм судлал	· Монгол хэл · Нийгэм судлал · Ур чадвар		
112.	15. Багш, хөгжмийн боловсрол	· Монгол хэл · Нийгэм судлал	· Монгол хэл · Нийгэм судлал · Ур чадвар		
113.	16. Багш, мэдээлэл зүйн боловсрол	· Математик · Физик	· Математик · Физик · Ур чадвар		
114.	17. Багш, математикийн боловсрол	· Математик	· Физик · Англи хэл		
115.	18. Багш, физикийн боловсрол	· Физик · Хими	· Физик · Хими · Математик · Англи хэл		
116.	19. Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол	· Монгол хэл	· Нийгэм судлал · Түүх		
117.	20. Багш, гадаад хэлний боловсрол (Англи)	· Англи хэл · Орос хэл	· Монгол хэл · Нийгэм судлал		
118.	21. Багш, бага боловсрол	· Монгол хэл · Математик	· Монгол хэл · Математик · Ур чадвар		
ХОВД АЙМАГ ДАХЬ САЛБАР СУРГУУЛЬ					
119.	1. Нягтлан бодох бүртгэл	· Математик	· Англи хэл · Нийгэм судлал		410
120.	2. Санхүү	· Математик	· Англи хэл · Нийгэм судлал		
121.	3. Эрхзүй	· Нийгэм судлал	· Математик		
122.	4. Программ хангамж	· Математик · Физик	· Математик · Физик · Нийгэм судлал · Англи хэл		
123.	5. Барилгын инженерчлэл	· Математик · Физик	· Математик · Физик · Нийгэм судлал · Англи хэл		
124.	6. Цахилгааны инженер	· Математик · Физик	· Математик · Физик · Нийгэм судлал · Англи хэл		
125.	7. Уул уурхайн ашиглалтын технологи	· Математик · Физик	· Математик · Физик · Газарзүй · Англи хэл		
126.	8. Геологи	· Математик · Физик	· Математик · Физик · Газарзүй · Англи хэл		

127.	9. Газар зохион байгуулалт	· Математик · Физик	· Англи хэл · Газарзүй
128.	10. Химийн боловсруулалтын технологи	· Хими · Математик	· Физик · Англи хэл
129.	11. Аялал жуулчлал	· Математик · Монгол хэл	· Математик · Монгол хэл · Нийгэм судлал · Англи хэл
130.	12. Бизнесийн удирдлага	· Математик	· Англи хэл
131.	13. Гадаад хэлний орчуулга (Англи)	· Англи хэл · Нийгэм судлал	· Математик · Монгол хэл
132.	14. Гадаад хэлний орчуулга (Хятад)	· Англи хэл · Нийгэм судлал	· Математик · Монгол хэл
133.	15. Нийгмийн ажил	· Нийгэм судлал · Англи хэл	· Нийгэм судлал · Монгол хэл · Англи хэл
134.	16. Нийгмийн эрүүл мэнд	· Хими · Нийгэм судлал	· Хими · Нийгэм судлал · Биологи · Англи хэл
135.	17. Нийтийн удирдлага	· Нийгэм судлал	· Англи хэл
136.	18. Ойн аж ахуй	· Газарзүй · Математик	· Газарзүй · Математик · Биологи · Нийгэм судлал
137.	19. Сэтгэл судлал	· Нийгэм судлал · Математик	· Нийгэм судлал · Математик · Монгол хэл · Англи хэл
138.	20. Экологи	· Биологи · Математик	· Хими · Нийгэм судлал
139.	21. Багш, дүрслэх урлагийн боловсрол	· Монгол хэл · Нийгэм судлал	· Ур чадвар
140.	22. Багш, дизайн технологийн боловсрол	· Монгол хэл · Нийгэм судлал	· Ур чадвар
141.	23. Багш, дизайн зураг зүйн боловсрол	· Монгол хэл · Нийгэм судлал	· Ур чадвар
142.	24. Багш, биеийн тамирын боловсрол	· Монгол хэл · Нийгэм судлал	· Ур чадвар
143.	25. Үндэсний язгуур урлаг	· Монгол хэл · Нийгэм судлал	· Ур чадвар
144.	26. Багш, сургуулийн өмнөх боловсрол	· Монгол хэл · Нийгэм судлал	· Монгол хэл · Нийгэм судлал · Ур чадвар
145.	27. Багш, хөгжмийн боловсрол	· Монгол хэл · Нийгэм судлал	· Монгол хэл · Нийгэм судлал · Ур чадвар
146.	28. Багш, бага боловсрол	· Монгол хэл · Математик	· Монгол хэл · Математик · Ур чадвар
147.	29. Багш, мэдээлэл зүйн боловсрол	· Математик · Физик	· Математик · Физик · Ур чадвар
148.	30. Багш, математикийн боловсрол	· Математик	· Физик · Англи хэл

149.	31. Багш, физикийн боловсрол	· <i>Физик</i> · <i>Хими</i>	· <i>Математик</i> · <i>Физик</i> · <i>Хими</i> · <i>Англи хэл</i>	
150.	32. Багш, биологийн боловсрол	· <i>Биологи</i> · <i>Математик</i>	· <i>Биологи</i> · <i>Математик</i> · <i>Хими</i> · <i>Англи хэл</i>	
151.	33. Багш, гадаад хэлний боловсрол (Англи)	· <i>Англи хэл</i> · <i>Орос хэл</i>	· <i>Монгол хэл</i> · <i>Нийгэм судлал</i>	
152.	34. Багш, гадаад хэлний боловсрол (Орос)	· <i>Англи хэл</i> · <i>Орос хэл</i>	· <i>Монгол хэл</i> · <i>Нийгэм судлал</i>	
153.	35. Багш, газарзүйн боловсрол	· <i>Газарзүй</i> · <i>Математик</i>	· <i>Газарзүй</i> · <i>Математик</i> · <i>Нийгэм судлал</i> · <i>Англи хэл</i>	
154.	36. Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол	· <i>Монгол хэл</i>	· <i>Нийгэм судлал</i> · <i>Түүх</i>	
155.	37. Багш, нийгмийн ухааны боловсрол	· <i>Нийгэм судлал</i>	· <i>Монгол хэл</i> · <i>Түүх</i>	
156.	38. Багш, химийн боловсрол	· <i>Хими</i> · <i>Математик</i>	· <i>Хими</i> · <i>Биологи</i> · <i>Математик</i> · <i>Англи хэл</i>	
БҮРЭЛДЭХҮҮН/САЛБАР СУРГУУЛИЙН ХАМТАРСАН ХӨТӨЛБӨРҮҮД				
ЗАВХАН АЙМАГ ДАХЬ САЛБАР СУРГУУЛЬ болон ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ				
2+2 хөтөлбөр**				
157.	1. Нийтийн удирдлага (ОУХНУС болон Завхан сургуулийн дотоодын хамтарсан хөтөлбөр)	· <i>Нийгэм судлал</i>	· <i>Англи хэл</i>	480
ЗАВХАН АЙМАГ ДАХЬ САЛБАР СУРГУУЛЬ болон ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛИЙН ХАМТАРСАН				
1+3 хөтөлбөр*				
158.	1. Хүрээлэн буй орчин судлал (ХШУИС болон Завхан сургуулийн дотоодын хамтарсан хөтөлбөр)	· <i>Хими</i> · <i>Математик</i>	· <i>Биологи</i> · <i>Нийгэм судлал</i>	
159.	2. Ойн аж ахуй (ХШУИС болон Завхан сургуулийн дотоодын хамтарсан хөтөлбөр)	· <i>Газарзүй</i> · <i>Математик</i>	· <i>Газарзүй</i> · <i>Математик</i> · <i>Биологи</i> · <i>Нийгэм судлал</i>	480
ШУТИС болон ДОРНОД АЙМАГ ДАХЬ САЛБАР СУРГУУЛИЙН ХАМТАРСАН ХӨТӨЛБӨР				
160.	1. Ашигт малтмалын баяжуулалтын технологи	· <i>Математик</i> · <i>Физик</i>	· <i>Математик</i> · <i>Физик</i> · <i>Газарзүй</i> · <i>Англи хэл</i>	410